БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2011 оны 9 дүгээр сарын 28 -ны өдөр А-320/ Дугаар 305/ Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах түр журам батлах тухай

"Яамны эрх зүйн байдлын тухай" Монгол Улсын хуулийн 7.1.2, 7.1.5 дах хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын 2001 оны "Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний тухай" 256 дугаар тогтоол, 2002 оны "Журам батлах тухай" 135 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Улсын болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Уг тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг 2011 оноос эхлэн жил бүрийн Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгах, Олон Улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл)-т үүрэг болгосугай

4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах, боловсруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Д.Жаргалсайхан), Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Л.Батжав), Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (Д.Оюунчимэг)-т тус тус даалгасугай.

6. Уг тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын хамтарсан 2002 оны 249/201 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

А-220/305

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2011 оны
9.. сарын 28..ны өдрийн 305.....дугаар
тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах түр журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын "Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай" хууль, Засгийн газрын 2001 оны "Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний тухай" 256 дугаар тогтоол, 2002 оны "Журам батлах тухай" 135 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2009 оны "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги батлах тухай" 293 дугаар тушаалд заасан эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг (цаашид "хог хаягдал" гэж тэмдэглэнэ) ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахтай холбогдсон үйл ажиллагааг улсын хэмжээнд зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 5 дугаар сарын 3-ны 158 болон 2011 оны 5 дугаар сарын 31-ны 179 дугаар тушаалаар батлагдсан зааврыг энэхүү үйл ажиллагааг гүйцэтгэхэд мөрдөж ажиллана.

1.3. Эрүүл мэндийн бүх шатны байгууллага нь эмнэлгийн тусгай хог хаягдлыг ангилах, ялгах, цуглуулах, савлах, хадгалах, түр байршуулах, халдваргүйтгэх, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

1.4. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтэд халдвар хяналтын алба / баг дотоодын хяналт тавьж ажиллана.

1.5. Эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлыг түр хадгалах шаардлага хангасан байр, хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үүрэг бүхий ажилтантай байна.

1.6. Байгууллагын хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх үүрэг бүхий ажилтан, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүс нь вируст гепатит В, татрангийн эсрэг вакцинжуулалтад заавал хамрагдсан байна.

1.7. Эрүүл мэндийн байгууллагууд шаардлага хангасан хогийн сав, уутаар хангана.

1.8. Халдвар хяналтын алба/баг нь хог хаягдлын менежментийн сургалтын асуудлыг хариуцаж тусгай хог хаягдлыг ангилах, ялгах, цуглуулах, савлах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах талаар шатчилсан сургалтыг ажиллагсдад тогтмол явуулна.

1.9. Хог хаягдалтай харьцаж ажиллаж буй эрүүл мэндийн байгууллагын эмч, ажиллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврыг дагаж мөрдөнө.

1.10. Эрүүл мэндийн байгууллага бүр хог хаягдлын тухай мэдээллийг Халдварт өвчин судлалын үндэсний төвд Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалын 3-р хавсралтад заасан маягтын дагуу дараа сарын 5-ны дотор ирүүлж байх бөгөөд Халдварт өвчин судлалын үндэсний төв хагас жил тутам мэдээллийг нэгтгэн Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тайланг хүргүүлнэ.

1.11. Энэхүү журмын биелэлтэд эрүүл ахуй, халдвар судлал, эм биобэлдмэл, байгаль орчны хяналтын улсын байцаагчид хяналт тавьж, журам зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцно.

Хоёр. Хог хаягдлыг ангилах, ялгах, савлах, цуглуулах, хадгалах, түр байршуулахад тавигдах шаардлага

2.1. Улсын болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлыг ангилах, ялгах, савлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

2.2. Тусгай хог хаягдлын уут, савыг өөр зориулалтаар болон дахин ашиглахыг хориглоно.

2.3. Хог хаягдал бүхий уут, савны 2/3-т хүрмэгц уутыг битүүмжлэн тасаг, нэгжийн тусгай хог хаягдлыг эмнэлгийн дунд мэргэжилтэн, ахуйн болон ердийн хог хаягдлыг тасгийн үйлчлэгч цуглуулан тухайн тасаг, нэгжийн хог хаягдлыг түр хадгалах цэгт зөөж хүргэнэ.

2.4. Тухайн эрүүл мэндийн байгууллагын халдвар хяналтын алба/багийн дарга тухайн тасаг, нэгжийн түр хадгалах цэгт цуглуулсан хог хаягдлыг эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг түр хадгалах байр руу зөөвөрлөх зам, цагийн хуваарийг тогтоож баталгаажуулсан байна.

2.5. Байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан нь батлагдсан хуваарийн дагуу тухайн тасаг, нэгжийн хог хаягдлыг түр хадгалах цэгээс эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байр руу зориулалтын тэргэнцрээр зөөвөрлөж, хог хаягдлыг жинлэн, бүртгэл хөтөлнө.

2.6. Тухайн тасгийн хэмжээнд хог хаягдлын ангилан ялгалтын байдалд тасгийн эрхлэгч, халдвар хяналтын алба/баг хяналт тавьж ажиллана.

2.7. Байгууллагын хог хаягдал хариуцсан ажилтан нь хөдөлмөр хамгааллын хувцас, малгай, амны хаалт, нүдний шил, гадуур хүрэм, гутал, тусгай бээлий зэрэг хувийн хамгаалах хувцас, хэрэглэлээр бүрэн хангагдсан байна.

2.8. Хог хаягдлыг түр хадгалах байранд хүйтний улиралд 72 цаг, дулааны улиралд 48 цагаас дээш хугацаанд хадгалж болохгүй.

Гурав. Хог хаягдлыг тээвэрлэхэд тавигдах шаардлага

3.1.Эрүүл мэндийн байгууллага бүр зориулалтын уутанд ангилж савласан тусгай хог хаягдлыг тагтай саванд хийж, тээвэрлэлтэнд бэлдэнэ.

3.2. Тээвэрлэлтийн шаардлага хангаагүй, уут савны бүрэн бүтэн байдал алдагдсан, ангилан ялгаагүй, зориулалтын бус саванд хийсэн, хэмжээ, нэр төрөл нь тодорхойгүй хог хаягдлыг хүлээн авч, тээвэрлэхийг хориглоно.

3.3. Тусгай хог хаягдлыг тээвэрлэхэд таних тэмдэг бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд хүн, мал, амьтан, бараа бүтээгдэхүүн болон бусад хог хаягдалтай хамт тээвэрлэхийг хориглоно.

3.4. Тухайн орон нутгийн засаг, захиргаа, замын цагдаагийн байгууллагатай зөвшилцөн батлагдсан цагийн хуваарь, маршрутын дагуу хог хаягдлыг тээвэрлэж эцсийн устгалын цэгт хүргэнэ.

3.5. Тээврийн хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

3.6. Эрүүл мэндийн байгууллагын тусгай хог хаягдлыг тээврийн хэрэгсэлд ачих, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүс ажлын цагаар халад, хормогч, малгай, амны хаалт, нүдний шил, гадуур хүрэм, гутал, тусгай бээлий зэрэг хувийн хамгаалах хэрэгсэл өмсөнө.

3.7. ЭМБ-ын хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад ерөнхий болон тусгай сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна.

3.8. Жолооч нь тээврийн хэрэгслийн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана.

3.9. Хог хаягдал гарсан цэгээс эцсийн цэг хүртэлх тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй халдвар, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үүргийг тээвэрлэгч хүлээнэ.

3.10. Тээвэрлэгч хог хаягдлыг тээвэрлэж дууссаны дараа тээврийн хэрэгслийг аюулгүй, хоргүй, халдваргүй болгох арга хэмжээ авна.

Дөрөв. Хог хаягдлыг халдваргүйтгэх, устгах, дахин боловсруулахад тавигдах шаардлага

4.1. Батлагдсан зураг төсөл, стандартын дагуу баригдсан зориулалтын байр/ байгууламж/цэгт аюулын зэрэглэл, төрлийг харгалзан хог хаягдлыг халдваргүйтгэх үйл ажиллагааг явуулна.

4.2. Хог хаягдлыг устгах, халдваргүйтгэх үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь шаардлага хангасан тоног төхөөрөмжтэй байх бөгөөд ажиллагсад нь хог хаягдлын менежментийн суурь сургалтанд хамрагдсан байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллага нь дахин боловсруулах, эргүүлэн ашиглах боломжтой хог хаягдлын менежментийн асуудлыг хариуцаж ажиллана.

4.4. Байгаль орчны сайдын 2006 оны 404 дүгээр тушаалын дагуу орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон цэгт хог хаягдлыг устгах үйл ажиллагааг явуулна.